



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 10 сарын 20 өдөр

Дугаар 508

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө, өр төлбөр бүртгэх  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.1.3, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол улсын Хөгжлийн банкны зээлийн санхүүжилтийн эх үүсвэрээр бий болсон нийт 122,965,660,152.49 (нэг зуун хорин хоёр тэрбум есөн зуун жаран таван сая зургаан зуун жаран мянга нэг зуун тавин хоёр төгрөг дөчин есөн мөнгө) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгө, дагалдах өр төлбөрийг “Монголын газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргал, Монголын газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Зээлийн санхүүжилтийн эх үүсвэрээр бий болсон бий хавсралтад заасан хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан Улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтаар хүлээн авах;

2.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бodoх бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2020 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн  
60.0 дугаар тогтооолын хавсралт

"МОНГОЛЫН ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР" ТӨРИЙН ӨМЧИТ ХЯЗГААРЛАГДМАЛ  
ХАРИУЦЛАГТАЙ КОМПАНИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСАЛТ

/төгрөгөөр/

№	Дэд бүтцийн актүүд	Гэрээний гүйцэтгэлийн дүн	Зээлийн хүүгийн зардал	Зөвлөх үйлчилгээний зардал	Нийт балансын дүн
1	17,5 км хунд даацын тусгай зориуулалтын авто зам	31,643,273,624	4,501,274,141	1,169,500,497	37,314,048,262
2	27 км салсаа темөр зам	66,006,770,062	10,805,704,993	2,439,537,429	79,252,012,484
3	18,2 км цахилгаан дамжуулах агаарын шугам	5,377,525,212	1,022,074,194		6,128,281,722
4	Дэд станц (110/35/10 кВ)				271,317,684
		103,027,568,898.00	16,329,053,327.73	3,609,037,926.41	122,965,660,152.49
					(Нэг зуун хорин хоёр тэрбум есөн зуун жаран таван сая зургаан зуун жаран мянга нэг зуун тавин хоёр төгрөг дөчин есөн мөнгө)
					Нийт дүн